


МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙН
ЖИШИГ СУРГУУЛЬ



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ



ДИПЛОМЫН ТӨСӨЛТ АЖИЛ

ТАНИЛЦУУЛГА ВИДЕО ШТОРК

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН
УДИРДСАН
ГҮЙЦЭТГЭСЭН

.....
М. Сандансүрэн
М. Хүтээнболор
.....



МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН ЖИШИГ СУРГУУЛЬ
ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

ТӨГСӨЛТИЙН ТӨСӨЛТ /ДИПЛОМ/-ЫН АЖИЛ

МЭРГЭЖЛИЙН ТАНИЛЦУУЛГА ШТОРК

Гүйцэтгэсэн *Н. Хутагбаяр*

Удирдсан *М. Сандансүрэн*

Үнэлгээ хийсэн *15%*

ЧОЙР ХОТ

2018 ОН

АГУУЛГА

2	АГУУЛГА
2	Зургийн гарчиг
3	ОРШИЛ
4	ЗОРИЛГО
4	ЗОРИЛТ
5	СУДАЛГААНЫ ХЭСЭГ
5	Шторк гэж юу вэ?
6	Бичлэгийн явц
6	Веб мультимедиа зохиогч
7	УУЛ УУРХАЙН МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН МЕХАНИК
8	ХҮНД МАШИН МЕХАНИЗМЫН АШИГЛАЛТЫН ТЕХНИКЧ
9	АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ТЕХНИКЧ
10	ХЭРЭГЛЭГДСЭН ПРОГРАМУУД
15	ИНТЕРНЭТЭЭС ХАЙЛТ ХИЙХДЭЭ АНХАРАХ ЗҮЙЛС
16	Ажлын үйл явц
22	Дүгнэлт

Зургийн гарчиг

16	Зургаг 1:Хэрэглэгдэх тэмдэглэгдсэнүүдийг бэлдэж буй нь
16	Зургаг 2:Оруулах дүүгт найруулсан нь
17	Зургаг 3:Бичлэгийн эхлэл хэсгийг хийж буй нь
17	Зургаг 4:Бичлэгт түсгэж өгөх мэргэжлүүдийн мэдээлэл цуглуулаж буй хэсэг
18	Зургаг 5:Хамгийн суулд бэлдсэн хэсгүүдийг нийлүүлэн 1 багц болгож буй нь
18	Зургаг 6: Мэдээлэл цуглуулаж буй нь
19	Зургаг 7: Ботино хэмжээний кино хийх зөвлөмж
19	Зургаг 8: хамгийн анхны түршил
20	Зургаг 9: 2 дахь түршил
20	Зургаг 10: гурав дахь түршил
21	Зургаг 11: Эцсийн байдлаар бичлэг эхлэж буй нь

ОРШИЛ

Бүхий л хүмүүс бага балчир наснаасаа ямар нэгэн мэргэжлийг сонгон түүнийгээ гайхан бишрэн дүрд нь тоглож өсдөг. Цаг хугацаа явж өсөхийн хирээр тойрон буй орчин болоод хүсэл зоригийн үйлчлэлээр аль нэг мэргэжлийг сонгон судалж амьдралын бас нэг зорилго, зорилт болгодог. Дипломын ажлаараа би удахгүй сургуулиа төгсөж өөрийн ирээдүйг бичих гэж буй дүү нартаа болоод шинэ мэргэжил эрэлхийлж буй хүмүүст зориулан өөрийн сургуулийн элсэлт авч буй мэргэжлүүдийн богинохон бөгөөд чухал мэдээлэл агуулсан дүрс бичлэг бүхий материал бэлтгэлээ.

ЗОРИЛГО

Хэрэгцээтэй гэсэн бүхий л мэдээлэл эх сурвалжийг цуглуулж гол зорилт болох шторкын мөн чанарыг таньж мэдэх.

Олон төрөл зүйлийн шторкын зүйл урсгал байдаг тус бүрийг тандан судалж тус бүрдээр жишээ гарган өөрийн сэдэвтэй тохирох эсэхийг турших. Загварын хамгийн сүүлийн үеийн бөгөөд хэрэглэгч хамгийн олон татдаг урсгалыг сонгон өөрийн бүтээх шторктоо хэрэгжүүлэх.

ЗОРИЛТ

Зорилтот үзэгчид болох сургуулиа төгсөж буй шилжилтийн нас нь эд дундаа яваа хүүхдүүдийн хүсэл зорилгод нийцэж сонирхолыг татах бичлэг хийх.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Шторк гэж юу вэ?

Шторк нь сүүдэр гэсэн орос үг ба сүүдэр шийг ч мөн шторк гэдэг байсан нь 20-р зууны сүүл үед гарч хар цагаан кино, нэвтрүүлгийг ийн нэрлэдэг болсноор ам дамжин явсаар одоо үед богино хэмжээний дүрс бичлэгийг шторк гэх болжээ.

Шторкын хувьд ерөнхий хэлбэр нь 30 секундээс 10 минут хүртэлх богино хэмжээний дүрс бичлэг боловч тус тусын бүтээгдсэн зорилго, үүргээс хамаараад олон төрөлтэй байна.

Ихэнх үед шторк нь бараа бүтээгдэхүүний зар сурталчилгаа, суртал ухуулга байх боловч урлагт мөн хүчтэй нөлөөтэй нь жил бүр болдог богино хэмжээний кино уралдаануудаас харагдана.

Миний бие шторкийн зур сурталчилгааны төрөл буюу intro-г сонгосон учир судалж үзэхэд

Intro нь бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөс хамаарч тус тусын гэсэн утга учир бүхий уран зохиолын төрөл зүйлтэй байна.

БИЧЛЭГИЙН ЯВЦ

Веб мультимедиа зохиогч

Хийж гүйцэтгэдэг ажил

Захиалагчаас өгсөн захиалга, хүсэлтийн дагуу бүх төрлийн бүтээгдэхүүний эхийг компьютерийн програм хангамж ашиглан үйлдвэрлэлийн технологийн шаардлагад нийцүүлэн бэлтгэж, хэвлэлтийн төрөл бүрийн ажиллагаа болон дүрс бүхий хэвлэл, мэдээллийн бусад хэлбэрт оруулна. Интернэтэд зориулсан мультимедиа, хөдөлгөөнт дуу дүрстэй бүтээгдэхүүний эхийг хийж гүйцэтгэнэ

Гүйцэтгэх үндсэн үүрэг чиглэл

Дизайныг хийх материалыг хүлээн авах Анхны эх нооргийн хийж дуусгах, хэвлэх Эх загвар дээрээ хяналт хийх Удирдлагаар хянуулан, захиалагчаас санал авч эх загвар дээр ажиллах Эх загварыг хэвлэлд бэлтгэх Ажлаа дуусгах

Ирээдүйн ахин дэвших боломж

Хэвлэлийн компани, зар сурталчилгааны агентлаг, график дизайны компани, видео тоглоом хөгжүүлэгч студи, хэвлэх үйлдвэр, маркетингийн болон PR компани, урлагийн болон хаяг рекламны студи, зураг төслийн компани, үйлдвэр байгууллагын дизайн зохион бүтээх нэгж, соёл, урлаг, боловсролын төрийн болон хувийн байгууллагад ажиллах Хувиараа зар сурталчилгаа, маркетинг, PR, хэвлэлийн компани, хэвлэх үйлдвэр, студи, жижиг цех, урлан байгуулж ажиллах Мэргэжлийн дагуу дараа шатны сургуульд дэвшин суралцах

Эдийн засгийн салбар дахь цалингийн сүлжээ

Соёл, урлагын салбарын ААНБ-ын ажилчдын нийт дундаж цалин 600600 төгрөг ба ажил мэргэжлийн ангилал, зэрэглэлээс шалтгаалан хэлбэлзэнэ

УУЛ УУРХАЙН МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН МЕХАНИК

Хийж гүйцэтгэдэг ажил

Уул уурхайд ашиглагдаж байгаа экскаватор, өрмийн машин, тээврийн машин бусад уул уурхайн машин тоног төхөөрөмжийн ажлын бэлэн байдлыг шалгах, засвар, техник үйлчилгээний ажлыг зохион байгуулах, хяналт тавьж, бүртгэл тооцоог хийх ажлыг гүйцэтгэнэ. Шинэ техник эзэмших, нутагшуулах, шаардлагатай сургалтын материал, гарын авлага бэлтгэх, аюулгүй ажиллагааны заавар, дүрмийг мөрдүүлэхэд оролцоно

Гүйцэтгэх үндсэн үүрэг чиглэл

Засварчдад хийх ажлын хуваарь танилцуулах Өдөр тутмын техникийн үйлчилгээг удирдлагаар хангах Засварын ажлыг хариуцан ажиллах, Засварчин болон бусад ажилтанд туслах Техникийн саатлыг оношлох, эд анги, механизмын тохиргоо хийх Ажлаа удирдлагад танилцуулах Хийсэн ажлаа бүртгэж, тэмдэглэл хөтлөх

Ирээдүйн ахин дэвших боломж

Нүүрсний уурхай, хүдрийн уурхай, эрдэс олборлох, боловсруулах үйлдвэр, алтны компаниудад мэргэжлээрээ тогтвор сууршилтай ажиллаж, мэргэжил ур чадвараа нэмэгдүүлэн өндөр зэрэгтэй мэргэжлийн ажилтан болох Механик инженерийн чиглэлээр ахисан шатны сургуульд суралцах

Эдийн засгийн салбар дахь цалингийн сүлжээ

ААНБ-д ажиллаж буй техникийн ажилтны сарын дундаж цалин 1103900 төгрөг ба ажил мэргэжлийн ангилал, зэрэглэлээс шалтгаалан хэлбэлзэнэ.

ХҮНД МАШИН МЕХАНИЗМЫН АШИГЛАЛТЫН ТЕХНИКЧ

Хийж гүйцэтгэдэг ажил

Хүнд машин механизм болон тоног төхөөрөмжийн компьютерийн системийг ашиглан онош тавих, дүн шинжилгээ хийх, ажиллуулах, засвар үйлчилгээ хийх зэрэг үүрэг гүйцэтгэнэ.

Гүйцэтгэх үндсэн үүрэг чиглэл

Онош тавих, дүн шинжилгээ хийх Шаардлагатай сэлбэг хэрэгсэл захиалах Схем зураг унших Засвар үйлчилгээ хийх, хянах ХАБЭА-н тухай хууль, дүрэм мөрдөн ажиллах

Ирээдүйн ахин дэвших боломж

Уул уурхай, барилга угсралт, авто замын салбарт ажиллах боломжтой. Их, дээд сургуульд суралцах

Эдийн засгийн салбар дахь цалингийн сүлжээ

Уул уурхайн салбарын нийт дундаж цалин 1109600 төгрөг ба ажил мэргэжлийн ангилал, зэрэглэлээс шалтгаалан хэлбэлзэнэ

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ТЕХНИКЧ

Хийж гүйцэтгэдэг ажил

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартын дагуу байгууллагын ажилтны аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах үүрэгтэй ажиллана.

Гүйцэтгэх үндсэн үүрэг чиглэл

ХАБЭА-н менежментийг хэрэгжүүлэх Осол гарсан үед яаралтай арга хэмжээ авах Бүртгэх Байгууллагын дотоод журам, зааврыг хамтран боловсруулах ХАБЭА-н сургалт зохион байгуулах, Урьдчилан сэргийлэх зан үйлийг ажилтнуудад төлөвшүүлэх Шинэ болон өөр ажилд шилжиж байгаа ажилтны сургалтыг зохион байгуулах, Шалгалт авахад биечлэн оролцох, Ажиллуулах зөвшөөрөл олгох Ажлын тусгай хувцсыг хэрэглэж хэвшүүлэх

Ирээдүйн ахин дэвших боломж

Мэргэжлээрээ идэвхи зүтгэл гарган ажиллаж мэргэжлийн зэрэг ахиулж, зэргийн болон олон жил ажилласны нэмэгдэл авч цалин хөлсөө нэмэгдүүлэх Инженерийн чиглэлээр дэвшин суралцах, ажиллах

Эдийн засгийн салбар дахь цалингийн сүлжээ

ААНБ-д ажиллаж буй техникийн ажилтны сарын дундаж цалин 1103900 төгрөг ба ажил мэргэжлийн ангилал, зэрэглэлээс шалтгаалан хэлбэлзэнэ.

ХЭРЭГЛЭГДСЭН ПРОГРАМУУД.

ADOBE PHOTOSHOP CS6

Adobe Photoshop програм нь растерийн дүрслэлийг бүтээдэг. PHOTOSHOP програмд дээр ажиллаж байгаа хамгийн том дүрслэлдийн тоо 30000x30000 pixel цэгийн харьцаатай хамгийн өндөр нягтрал нь 10000dpi байдаг. Файлын хамгийн том хэмжээ нь 2GB байдаг.

Уг програм дээр ажилладаг мэргэжилтэн нь дэлгэцэнд өөрийн дүрслэн бодсоноороо ямар ч зохиомжийг зурж байгуулж болох ба түүний хувилбаруудыг хадгалах тэднийг сканнердсан дүрслэлтэй нь хослуулан зохицуулах нийлүүлэх, дүрсний шилжилт, зөөлт болон фильтрийн олон аргуудыг хэрэглэдэг.

PhotoShop програмаар шинээр шинэ файл үүсгэхэд энэ нь нэг цэг дээр олон өнгийг олгох чадвартай давхаргатай зураг үүсгэдэг. Ийм учраас энэхүү програмд зургийн файльтай ажиллаж байх үед хийгдэж байгаа өөрчлөлт нь зөвхөн идэвхтэй давхаргын хувьд хийгддэг.

Зургийн өнгөний модель

Шинэ файл үүсгэх команд (FILE-NEW) өгөхдөө тухайн зургийг ямар өнгөтэй үүсгэх вэ гэдгийг MODE параметрт зааж өгнө.

BITMAP: Зургийн нэг цэгт хар цагаан гэсэн хоёр өнгийг л дүрслэх чадвартай. Өөрөөр хэлбэл хар цагаан зургийн төрөл. Ижил хэмжээтэй зургуудаас хамгийн бага зай эзэлнэ.

GREYSCALE: Хар, хар саарал, саарал цайвар гэх мэтээр цагаан өнгөнд хүртэл нийт 256 төрлийн өнгийг агуулна. RGB COLOR: Улаан, ногоон, хөх гэсэн гурван өнгөнөөр нийт 16,7 сая төрлийн өнгийг дүрсэлж чаддаг. CMYK COLOR: Өнгийг цэнхэр, ягаан, шар, хар гэсэн 4 өнгөөр салгаж дүрслэнэ. RGB color төрлөөс арай муу харагдана. Энэ төрлийг голдуу өнгөтөөр хэвлэх зурганд хэрэглэдэг. Бусад төрлүүдээсээ хамгийн их зай эзэлдэг. LAB COLOR: Өнгийг гурван төрлийн негатив өнгүүдээр дүрслэнэ. Зургийн төрлийг өөрчлөхдөө программын цэснээс Image/Mode командыг ашиглана. IMAGE SIZE бүлэгт зургийн хэмжээтэй холбоотой тохиргоог хийнэ. Preset Sizes: Зургийн талбайн хэмжээ. Энд inch-ийн харьцаагаар болон стандарт цаасны хэмжээнүүдийг сонгоно. Width & Height: Зургийн өндөр ба өргөний хэмжээ. Resolution: Зургийн өнгний нягтралыг тодрхойлж өгнө. Нэг inch-д ноогдох цэгийн тоог Pixel гэдэг.

Монгол улсын хэмжээнд сүүлийн жилүүдэд интернэт ашиглагчдын тоо нэмэгдэжүүний хэрэгцээгээр энэ талын чиглэлээр олон компаниуд үйл ажиллагаагаа явуулж байна. Тэдэнд сүүлийн жилүүдэд хөдөлгөөнт зураг буюу animation хэлбэрээр төрөл бүрийн вэб дизайн зохиох шаардлага урган гарч байгаа үүнийг мэрэгжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэхэд зайлшгүй Flash программыг эзэмших шаардлагатай байгаа юм. Flash программыг анх Jonathan Gay хөгжүүлсэн бөгөөд Jonathan Gay, Charlie Jackson, and Michelle Welsh нар 1993 оны 1-р сард худалдаанд гаргаснаар олны сонирхлыг татаж улмаар 1995 онд Macromedia корпораци худалдан авч өөрийн багцдаа нэгтгэсэн бөгөөд тэд 1-8-р хувилбар хүртэл хөгжүүлж ирсэн. Харин 2005 онд Adobe фирм тус компанийг худалдаж авсанаар Flash программ Adobe creativesuite багцанд орж улам хүчирхэг, олон олон шинэ боломжууд нээгдсэн юм. Macromedia Flash 1 (1996 оны 11-р сар): Анимэйшний эхний хувилбар Macromedia Flash 2 (1997 оны 6-р сар): Flash Player 2 -г нэмсэн Macromedia Flash 3 (1998 оны 5-р сарын 31): Flash Player 3-г гарган movieclip болон JavaScript –г дэмждэг болсон Macromedia Flash 4 (1999 оны 7-р сарын 15): Flash Player 4-г гарган шинэ шинэ хувьсагчийг нэмсэн ActionScript-ийн анхны хувилбарыг гаргасан Macromedia Flash 5 (2000 оны 8-р сарын 24): Flash Player 5-г гарган XML гарган динамик вэб хийх HTML форматыг нэмж өгсөн Macromedia Flash MX (хувилбар 6, 2002 оны 3-р сарын 15): Flash Player 6-г гарган Unicode-г дэмжих системийн нэвтрүүлжээ. Macromedia Flash MX 2004 (хувилбар 7, 2003 оны 9-р сарын 9): Flash Player 7-г гарган объект хандалтат Actionscript 2.0 хэлийг гарган вэбийн видео хувилбарт таарах MP3 болон FLV –ийг нэмэн Transition ангийг нэмж гаргасан байна. Macromedia Flash 8 (2005 оны 9-р сарын 13): хялбар товчлуурууд болон antialias-г гаргасан бөгөөд өмнөх хувилбаруудаас хэрэглэхэд илүү хялбар ирсэн юм. Adobe Flash CS3 Professional (хувилбар 9, 2007 оны 4-р сарын 16): энэ багцаас эхлэн Adobe-ийн нэрээр нэрлэгдэх болсон бөгөөд ActionScript 3.0-г гарган мөн тус фирмийн бүтээгдэхүүн болох, Adobe Photoshop, ба вектор зурагт Adobe Illustrator болон Adobe Fireworks-той хамтаар хэрэглэх Бололцоог бүрдүүлж өгсөн

ADOBE AFTER EFFECT CS6 Composite

Composite гэдэг нь холих, нилүүлэх гэсэн утгатай үг бөгөөд 2D хавтгай зураг авалтын видео 3D биетүүд болон бусад 2D элементүүдээр нийлүүлэн илүү сонирхолтой, төгс видео бүтээдэг компьютер графикийн арга юм. Composite график хийхийн тулд графикч нарийн мэдрэмжтэй байж тухайн орчны өнгө, гэрэл, сүүдэр, хавтгайн хөдөлгөөн зэрэгт маш сайн тааруулж байж яг нийлмэл нэг дүрс болдог. 2D орчинд 3D биетүүд оруулахын тулд бичсэн дүрсний орон зайг тракин буюу мэдрэх хэрэгтэй болно. Ингэж байж камерний хөдөлгөөн болон биетийн хөдөлгөөнийг яг дагасан, тухайн газар яг байгаа мэт болдог. Мөн Composite нь мате пайнт буюу хавгайд нь эвлүүлэг хийдэг арга байдаг. Энэ дандаа хавтгай дүрснүүдээр цоолох болон alpha суваг ашиглан хийдэг. Composite хийдэг нилээн олон програмууд байдгаас мэргэжлийн түвшинд хийж чаддаг буюу өргөн ашиглагддаг нь Nuke, After effects, Composite юм. Энэ төрлийн графикийг VFX буюу Visual Effects гэж нэрлэдэг.

та бидний үзэх дуртай бүхий л нэвтрүүлүүд, төлөвзийн шоуг Adobe Premiere хэмээх программаар монтажилдаг юм. Бүгд гэж хэлж болохгүй л дээ, видео монтаж хийдэг програмүүд зөндөө л бий. Гэвч монголд Adobe фирмийн Premiere-ийг л хэрэглэдэг. Дэлхийд ч гэсэн хамгийн их хэрэглэдэг нь энэ юм. Ер нь камераар авсан зургийг заавал монтаж хийх засах шаардлагатай байдаг. Тэр тусмаа сонирхогчийн камераар авсан бичлэгийг шууд үзэхэд алдаатай кадрууд байх нь олонтой. Иймээс ямар ч бичлэгийг монтаж хийж хасаж янзлан зассаны дараа үзэхэд урамтай сайхан болдог. Монтажны хамгийн сонгодог жишээ бол видео клип юм. Клипэн дээр олон кадруудыг залган нэг бүхэл видео гаргасан байдаг шүү дээ. Захиалгат нэвтрүүлэг, мэрэжлийн нэвтрүүлүүд, ярилцлага, спортын тойм, хүүхдийн нэвтрүүлэг, кино, хүүхэлдэйн кино, мэдээ, баримтат кино, компьютер Таймс нэвтрүүлэг зэрэг нь бүгд л эцсийн эцэст Premiere-ээр дамжсан байдаг.

Premiere-ийн сонгодог тодорхойлолт гэвэл яг тухайн алсны амьд видео засварлах програм хангамж гэвэл танд ойлгогдож байна уу. Premiere бол агуу их Adobe фирмийн асар олон програмуудын нэг юм. Тэгээд ч энэ програм нь өөрийн салбартаа тэргүүлэгчийн байрыг олон жил хадгалж байгаа билээ. Энэ програм нь видео боловсруулах, монтаж хийхтэй холбоотой бүхий л арга технологи, патентуудыг өөртөө агуулна. Видео монтаж хийдэг тусгай зориулалтын картууд, чип, кодууд нь энэ програмтай сайхан зохицон ажиллах болно. 2003 онд Adobe Premiere-ийн шинэ хувилбар Pro нь зах зээлд танилцуулагдсан. Бас Adobe-ийн бүтээгдэхүүнүүдийн гол давуу тал болох Macintosh компьютерүүд дээр мөн адил ажиллана. Гэвч Pro-ын хувьд Mac OS үйлдлийн систем дээр ажилладаг хувилбар нь 2007 онд л гарах ажээ. Premiere Pro нь дэлхийн хэмжээнд томоохон кино, видео хуртл монтажах хэмжээнд хурцад байна. Саяхныг хүртэл томоохон видео өөрөөр хэлбэл кино мэтийг дан програмын аргаар монтажахад төвөгтэй байлаа. Тэвэл одоогийн техник хангамж, програм нь ийм боломжийг бодитойгоор санал болгох болжээ. Тухайлбал Dust to Glory, Dana Brown, Superman Return зэрэг бүрэн хэмжээний уран сайхны киног энэ програмыг ашиглан монтажилсан гэнэ. 2004 онд гарсан Pro 1.5 хувилбар нь өнөөдөр та бидний дунд жинхэнэ дуулиан болоод байгаа High Definition видео буюу Өндөр Нятрлалтай видео боловсруулах чадалтай болсон. Бас шинэ шинэ төслийн менежмент, баражууд, филтер, эффектуудийг санал болгож байна. Ер нь мэрэжлийн, тэр тусмаа ийм мэрэжлийн програмуудыг тайлбарлах хэцүү байдаг. Учир нь энэ бүрийн төвөгтэй нэр томъёонууд их гардаг юм. Жишээ нь Premiere-ийн хамгийн сүүлд гарсан Pro 2.0 хувилбар нь HD, SD, DV-г боловсруулах чадалтай гэж байгаа. Ер нь Premiere нь бүх төрлийн формат бүхий видеог эх үүсвэр болгон оруулж авч чадах бөгөөд бас л бүх төрлөөр экспорт буюу гаргаж чадна. Зөвхөн энэ програмыг эзэмшихийн тулд тусгай сургуульд сурч, дээд боловсрол эзэмшдэг гэж байгаа. Манайхаар бол эвлүүлэгч гэх юмуу дээ. Монголд бол яахав дээ, нөгөө л авьяастай гарууд маань оролдсоор байгааг сурчихдаг юм. Тэгдээ тун дажгүй эзэмшсэн хүмүүс бол бий л дээ. Гэвч тэдний хажуугаар хоёрын хооронд сурчихаад эд мэдэхгүй хүн эдийн нэр гутаана гэгчээр олонтой эзэмшиж чаддаггүй байж программаа муу хэлж байгаа олонгүй нөхөд байдаг л юм. Ийм хүмүүс байвал тэдгээр юмаа битий хийгээрэй. Энэ програм бол тусгай мэрэжлийн програм учраас асар олон зүйл чадна. Видео

Богино хэмжээний мэргэжлийн
танилцуулга видео шторх

Бөб Мультимедиа Зохиогч 3А Ц.Хатанболд
14 | Хүүдас

Монтаж хийнэ гэдэг нь тэр болгон аавын хүүгийн чадлах ажил биш ээ. Програмаа дахгүй
эзэмшиж чадлаа ч гэсэн монтаж хийхэд тухайн хүнээс бага зэргийн авьяас шаардах
болно.

ИНТЕРНЭТЭЭС ХАЙЛТ ХИЙХДЭЭ АНХААРАХ ЗҮЙЛС

Интернэт хэрэглэгчид ихэвчлэн текстэн мэдээлэл, файл (зураг, дуу, программ г.м) хайх, худалдаа хийх, их дээд сургуульд суралцах зорилгоор хайлтын системийг ергөн ашиглаж байна.

Интернэт хэрэглэгчдэд цаг хэмнэж оновчтой хайж, хурдан олоход туслах хайлтын оператор командуудын талаар товчхон дурдъя.

Доорхи хайлтын командуудыг ашиглаж хайлтын системд хайлтаа хурдан хийх боломжтой.

Define: гэсэн команд нь тухайн үгний олон хэл дээрх тодорхойлолт буюу тайлбарыг гаргаж ирнэ. Үүнийг словарь болон шинжлэх ухааны тайлбар толь ашиглалгвйгээр тухайн үгний олон хэлний тайлбарыг олоход ашиглана.

Жишээлбэл: Define:USA товчилсон үгний Англи, Испани, Итали, Португали гэх мэт олон хэлээрх тодорхойлолтыг үзэж болно.

Filetype: Энэхүү командыг өөрийн хвссэн өргөтгөлтөй файл, баримт хайхад хэрэглэнэ. Өргөн хэрэглэдэг MS Office-ийн Word ".doc", Excel ".xls" Powerpoint ".ppt" өргөтгөл, Adobe Acrobat Reader ".pdf" гэх мэт төрөл бүрийн файлыг хайж болох юм.

Жишээлбэл: дипломын ажил filetype:doc гээд бичихэд төрөл бүрийн сэдвээр MS Word дээр хийгдсэн дипломын ажлууд гарч ирнэ.

Site: команд нь хайлтаа ямар өргөтгөлтэй сайтуудаас хайхыг тодорхойлно.

Монголын сайт ".mn", боловсролын сайтуудаас хайх ".edu.mn", ".edu" гэх мэтээр хайх бөгөөд хайлтынхаа хүрээг хумьж оновчтой хайлт хийхэд тусална.

Жишээлбэл: American college site:edu Хайлтын үр дүнд зөвхөн АНУ-ын боловсролын ".edu" өргөтгөлтэй коллежийн сайтуудыг харуулна.

In командын тусламжтай өөр нэгж хэмжээсүүдийг хооронд нь шилжүүлэн гаргаж болдог. Жишээлбэл: 3 miles in km Майлын хэмжээсийг километрт шилжүүлэх. 23 USD in Euros, 130 lbs in kg, 98.6 Fahrenheit in Celsius, 1 year in seconds гэх мэт.

Хайлтын системийн командын талаар дэлгэрэнгүй мэдээллийг

http://www.googleguide.com/advanced_operators.html вэб хуудаснаас авч болно. Дээрх командуудыг зөвхөн Google, Yahoo вйлчилгээгээр хязгаарлахгүйгээр бусад хайлтын системүүдэд ашиглаж болдог.

Mfn тооны нэмэх хасахаас эхлээд функцүүд ашиглан тоо бодож болдог.


<http://www.googleguide.com/help/calculator.html> хэсгээс хайлтын системд хийж болох тооны вйлдлийн талаарх мэдээллийг аварай.

<http://www.allonesearch.com> хайлтын систем.


Энэ нь бусад хайлтын вйлчилгээнүүдтэй нэгдсэн

томоохон хайлт юм. Та бүхэн хайлт хийхээс гадна Translators хэсгээс нэг хэлнээс нөгөө хэл рүү өгүүлбэрээр орчуулдаг онлайн толь бичгүүд, Academic Research хэсгээс курс, дипломын ажил, Music & MP3 Search Engines хэсгээс төрөл бүрийн дуу хөгжим программ бүхий файлын хайлт хийх боломжтой. Тухайлбал, Translators хэсгийн Babel


Ажлын үйл явц




Зураг 1:Хэрэглэгдэх тэмдэглэгээнүүдийг бэлдэж буй нь



Зураг 2:Оруулах дууг найруулсан нь




Зураг 7: Богино хэмжээний кино хийх зөвлөмж



Зураг 8: хамгийн анхны туршилт

6 ШАЛГАХ



**ТЕХНИКИЙН ШАЛГАЛТ
ВЕБ ХӨТЧИЙН ТААРАМЖ
ВЕБ САЙТ ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭЖ БУЙГ ШАЛГАХ**

Зураг 9: 2 дахь туршилт



Зураг 10: гурав дахь туршилт

УУЛ УУРХАЙН ЖИШИГ СУРГУУЛЬ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ



Зураг 11: Эцсийн байдлаар бичлэг эхлэж буй нь